



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/159

Мөрөн сум

Аймгийн бүсийн хурдан морины
уралдааныг товлон зарлах, зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Биеийн тамир спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Морин спорт уяачдын холбооны саналыг үндэслэн аймгийн хэмжээнд 2023 онд зохион байгуулагдах хурдан морины бүсийн уралдааны хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн бүсийн хурдан морины уралдааныг зохион байгуулахдаа хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулагчийн зүгээс онцгой анхаарч холбогдох байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж хамтран ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (хурандаа А.Алтанцоож), Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр), холбогдох сумдын Засаг дарга, аймгийн Морин спорт уяачдын холбоо, сумдын салбар холбооны удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатарт)-д даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны 04
дүгээр сарын 14-ний өдрийн А/159 дугаар
захирамжийн хавсралт

АЙМГИЙН БҮСИЙН ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЫ
2023 ОНЫ ХУВААРЬ

№	Уралдааны нэр	Зохион байгуулах газар	Уралдааны нас, ангилал	Зохион байгуулах хугацаа	Зохион байгуулагч
1	Жаргалант хурд-2023	Жаргалант суманд	Бага гурван нас, сонгомол дунд, бага нас	2023.05.03	Жаргалант хурд МСУХ, ЗДТГ
2	Шишгэд хурд-2023	Цагааннуур суманд	Бага гурван нас, сонгомол дунд, бага нас	2023.05.05	Цагааннуур сумын МСУХ, ЗДТГ
3	"Даян Дээрхийн хурд-2023"	Цагаан-Үүр суманд	Бага гурван нас, сонгомол дунд, бага нас	2023.05.05	Даян Дээрхийн Хурд МСУХ, ЗДТГ
4	Аймгийн Баруун бүсийн хурд-2023	Бүрэнтогтох суманд	Дээд гурван нас, сонгомол дээд нас	2023.06.25	Чингүнжавын хүлэг МСУХ, ЗДТГ
5	Аймгийн зүүн бүсийн уралдаан "Тосонгийн хурд-2023"	Тосонцэнгэл суманд	Дээд гурван нас, сонгомол дээд нас	2023.06.25	Тосонгийн хурд МСУХ, ЗДТГ
6	"Чандмань хурд-2023"	Чандмань-Өндөр суманд	Бага гурван нас, сонгомол дунд, бага нас	2023 оны 07 дугаар сарын 15-17	Урианхайн Хурд МСУХ, ЗДТГ

_____оОо_____